# САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

2016 ба 2017 оны 12 сарын 31-нд төгссөн жилүүдийн санхүүгийн нэгдсэн тайлангууд

*(Канад доллар)*

KPMG

Суит 1500 Пурдигийн Уорф Тауэр 1
1959 Аппер Уотер гудамж
Халифакс, NS B3J 3N2
Канад

Утас (902) 492-6000

Факс (902) 492-1307

www.kpmg.ca

# БИЕ ДААСАН АУДИТОРУУДЫН ТАЙЛАН

Эрдэнэ Ресурс Девелопмент Компаний хувьцаа эзэмшигчдэд зориулав
Бид Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2016, 2017 оны 12 сарын 31-ны байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байр суурь, нэгдсэн дэлгэрэнгүй алдагдлын тайлан, тухайн жилд дууссан өмчийн болон мөнгөн урсгалын өөрчлөлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлого болон бусад тайлбарт мэдээллийн хураангуйгаас бүхий тайлбараас бүрдсэн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийв.

*Санхүүгийн нэгдсэн тайлангийн хувьд удирдлагын гүйцэтгэх үүрэг хариуцлага*
Удирдлага нь санхүүгийн нэгдсэн тайланг Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудын дагуу боловсруулж, үнэн зөвөөр танилцуулах хариуцлагыг үүрэх бөгөөд энэхүү дотоод хяналтын хувьд удирдлага санхүүгийн нэгдсэн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүдэлтэй баримт бичгийн буруу үг өгүүлбэргүй бэлтгэгдсэн байхыг хангана.

*Аудиторуудын хариуцлага*
Бидний үүрэг хариуцлага бол өөрсдийн хийсэн аудит дээр үндэслэн эдгээр санхүүгийн нэгдсэн тайлангийн талаар үзэл бодлоо илэрхийлэх юм. Бид аудитаа Канад улсын нийтэд хүлээн зөвшөөрөгддөг аудитын стандартын дагуу явуулсан. Эдгээр стандартууд нь биднийг ёсзүйн шаардлага болон төлөвлөгөөг дагаж мөрдөхийг мөн санхүүгийн нэгдсэн тайлангууд нь баримт бичгийн буруу үг өгүүлбэргүй гэдгийг хангалттай хэмжээнд батлах аудитын гүйцэтгэл хийхийг шаарддаг.
Аудитын үйл ажиллагаа нь санхүүгийн нэгдсэн тайлангуудад дурдсан дүн хэмжээ болон мэдээллийн нээлттэй байдлын талаар аудитын баримт нотолгоо гаргаж ирэх гүйцэтгэлийн процедуртай байдаг. Сонгогдсон процедур нь бидний шийдвэр, үүнд санхүүгийн нэгдсэн тайлангууд дах залилан эсвэл алдаанаас үүдэлтэй баримт бичгийн буруу үг өгүүлбэрийн талаарх эрсдлийн үнэлгээ багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийх явцад бид хуулийн этгээдийн дотоод хяналтын үр өгөөжтэй байдлын талаар үзэл бодлоо илэрхийлэх бус харин нөхцөл байдалд тохирсон аудитын процедурыг гаргаж ирэхийг зорилгоор хуулийн этгээдийн санхүүгийн нэгдсэн тайланг боловсруулсан байдал болон үнэн зөв танилцуулгатай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн аудитын ажиллагаанд дагаж мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын зүгээс хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын зүйл зохистой байдал мөн санхүүгийн нэгдсэн тайлангуудын ерөнхий танилцуулгад үнэлгээ хийсэн болно.
Бидний итгэж буйгаар бидний аудитын үйл ажиллагаандаа олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний аудитын үзэл бодлын хувьд хангалттай, зүй зохистой бөгөөд үндэслэлтэй байна.

*Үзэл бодол*
Бидний үзэж буйгаар Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2015, 2016 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн байр суурийг санхүүгийн нэгдсэн тайлангуудад бүхий л баримт бичгийн хувьд мөн ба санхүүгийн нэгдсэн гүйцэтгэл, мөнгөний урсгал нь тухайн төгссөн жилүүдэд Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудын дагуу үнэн зөв танилцуулсан

KPMG LLP бол Канадын хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл бөгөөд KPMG ОУ-ын Хоршооны бие даасан гишүүн компаниудын сүлжээний гишүүн компани юм (“KPMG Интернейшнл”), Швейцарийн байгууллага.
KPMG Канад нь KPMG LLP-д үйлчилгээ үзүүлдэг

*Баримт бичигт онцолж үзсэн асуудал*

Өөрсдийн үзэл бодлоо өөрчлөлгүйгээр Эрдэнэ Девелопмент Компани 2016 болон 2017 онуудын үйл ажиллагаандаа алдагдал болон сөрөг мөнгөний урсгалтай байсныг харуулсан санхүүгийн нэгдсэн тайлангуудын Тайлбар 2 дээр бид анхаарал татсан билээ. Компани өөрийн үйл ажиллагаа болон төлөвлөсөн зардлаа нэмэлт санхүүжилтгүйгээр 2018 оны хоёрдугаар хагасаас хойш санхүүжүүлэх хангалттай хөрөнгөгүй байна. Эдгээр нөхцөл болон санхүүгийн нэгдсэн тайлангуудын Тайлбар 2-т дурдсан бусад асуудлууд Эрдэнэ Девелопмент Компани цаашид үргэлжлүүлэн ажиллах чадвартай эсэх онцгой эргэлзээг төрүүлэхүйц материалын тодорхой бус байдал буйг харуулж байна.




Мэргэжлийн нягтлан бодогчид, Тусгай зөвшөөрөлтэй нийтийн нягтлан бодогчид
2017 оны 3 сарын 28
Халифакс, Канад

KPMG LLP бол Канадын хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл бөгөөд KPMG ОУ-ын Хоршооны бие даасан гишүүн компаниудын сүлжээний гишүүн компани юм ("KPMG Интернейшнл"), Швейцарийн байгууллага.
KPMG Канад нь KPMG LLP-д үйлчилгээ үзү

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОМПАНИ

**Санхүүгийн байр суурийн нэгдсэн тайлан**

(Канад доллар)

| | Тайлбар | | 2017 оны 12-р сарын 31 | | 2016 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| **Эргэлтийн хөрөнгө**: | | | | | |
| Мөнгө болон мөнгөтэй адилтгах | | **$** | **3,225,202** | $ | 1,071,209 |
| Авлага | **6** | | **148,069** | | 36,854 |
| Урьдчилж төлсөн зардал | | | **47,479** | | 39,743 |
| | | | **3,420,750** | | 1,147,806 |
| Эргэлтийн бус хөрөнгө: | | | | | |
| Хайгуул, үнэлгээний хөрөнгө | **7** | | **11,394,843** | | 3,066,211 |
| Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж | **8** | | **130,283** | | 79,418 |
| | | | **11,525,126** | | 3,145,629 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **$** | **14,945,876** | **$** | 4,293,435 |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | | |
| Богино хугацаат өр төлбөр: | | | | | |
| Худалдааны болон бусад өглөг | | **$** | **191,600** | $ | 182,644 |
| | | | **191,600** | | 182,644 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **$** | **191,600** | $ | 182,644 |
| **ӨМЧ** | | | | | |
| Хувьцаа эзэмшигчдийн өмч: | | | | | |
| Хувьцаат капитал | **12** | **$** | **99,890,270** | $ | 86,783,669 |
| Хувь нийлүүлсэн нэмэгдэл | | | **13,775,386** | | 11,952,465 |
| Хуримтлагдсан Дэлгэрэнгүй алдагдал | | | **(894,855)** | | (636,283) |
| Алдагдал | | | **(98,016,525)** | | (93,989,060) |
| | | | **14,754,276** | | 4,110,791 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | **$** | **14,945,876** | $ | 4,293,435 |

Үүрэг хариуцлага (Тайлбар 9)

Удаа дараагийн үйл явдлууд (Тайлбар 19)

Дагалдах тайлбарууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

ТУЗ-ын өмнөөс баталсан:

*Гарын үсэг зурсан “Петер Си.Акерли”*

___________________________________ Захирал

*Гарын үсэг зурсан “Жон П. Бирне”*

___________________________________ Захирал

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОМПАНИ

**Дэлгэрэнгүй алдагдлын нэгдсэн тайлан**

(Канад доллар)

| | Тайлбар | 12 сарын 31-нд төгссөн жил 2017 | 2016 |
|---|---|---|---|
| Хайгуулын зардал | **14** | **$ 1,631,628** | $ 2,171,792 |
| Байгууллага, захиргаа | **15** | **2,450,152** | 1,446,888 |
| Валют арилжааны гарз (олз) | | **37,190** | (2,894) |
| Үйл ажиллагаа явуулснаас хүлээсэн алдагдал | | **4,118,970** | 3,615,786 |
| Санхүүгийн орлого | | **91,505** | 11,955 |
| Доор дурдсанаас өмнөх алдагдал | | **4,027,465** | 3,603,831 |
| Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын борлуулалтын орлогоос хувь авах эрхээ худалдсаны олз | **7** | **-** | 623,028 |
| Түргэн борлогдох үнэт цаас борлуулсны олз | **7** | **-** | 481,064 |
| Цэвэр алдагдал | | **$ 4,027,465** | $ 2,499,739 |
| Дэлгэрэнгүй алдагдал: | | | |
| Гадаад дахь охин компаниудын гадаад валютын хөрвүүлгээс үүдсэн ханшийн зөрүү | | **258,572** | 294,445 |
| Нийт дэлгэрэнгүй алдагдал | | **$ 4,286,037** | $ 2,794,184 |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан алдагдал | | **$ 0.03** | $ 0.02 |
| Гаргасан хувьцааны тайлант үеийн үндсэн болон хорогдуулсан нийт тооны жигнэсэн дундаж | | **142,916,756** | 117,127,676 |

Дагалдах тайлбарууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОМПАНИ

**Өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан**

**(Канад доллар)**

| | Тайлбар | Хувьцаан ы тоо | Хувьцаат капитал | Хувь нийлүүлсэн нэмэгдэл | Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал | Алдагд ал | Нийт өмч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | | 105,060,005 | $ 81,967,477 | $ 11,945,440 | $ (341,838) | $ (91,489,321) | $ 2,081,758 |
| **Хугацаанд тооцогдсон нийт дэлгэрэнгүй алдагдал:** | | | | | | | |
| Цэвэр алдагдал | | - | - | - | - | (2,499,739) | (2,499,739) |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | - | - | - | (294,445) | - | (294,445) |
| Хаалтай хүрээнд хувьцаа гаргаснаас орсон мөнгөн дүнгээс гаргалтын зардлыг хассан цэвэр дүн | 12 | 6,063,830 | 1,478,858 | - | - | - | 1,478,858 |
| Хаалтай хүрээнд гаргасанваррант | 12 ба 13 | 1,801,475 | 252,207 | - | - | - | 252,207 |
| **Хэрэгжүүлсэн варрант** | 12 ба 13 | 13,564,721 | 3,016,502 | (507,664) | - | - | 2,508,838 |
| **Хэрэгжүүлсэн опцион** | 12 ба 13 | 320,000 | 68,625 | (20,475) | | | 48,150 |
| **Хувьцаан дээр үндэслсэн нөхөн төлбөр** | | - | - | 535,164 | | | 535,164 |
| **Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ** | | 21,750,026 | 4,816,192 | 7,025 | - | - | 4,823,217 |
| **2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | | 126,810,031 | $ 86,783,669 | $ 11,952,465 | $ (636,283) | $ (93,989,060) | $ 4,110,791 |
| **2017 оны 1 дугаар сарын 1-нээрх үлдэгдэл** | | **126,810,031** | **$ 86,783,669** | **$ 11,952,465** | **$ (636,283)** | **$ (93,989,060)** | **$ 4,110,791** |
| **Хугацаанд тооцогдсон нийт дэлгэрэнгүй алдагдал:** | | | | | | | |
| Цэвэр алдагдал | | **-** | **-** | **-** | **-** | **(4,027,465)** | **(4,027,465)** |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | **-** | **-** | **-** | **(258,572)** | **-** | **(258,572)** |
| Хаалтай хүрээнд хувьцаа гаргаснаас орсон мөнгөн дүнгээс гаргалтын зардлыг хассан цэвэр дүн | **12** | **18,465,555** | **12,925,316** | **-** | **-** | **-** | **12,925,316** |
| **Нөхөн төлбөрийн опцион** | **12** | **-** | **-** | **322,597** | **-** | **-** | **322,597** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрэгжүүлсэн опцион | 12 ба 13 | 687,500 | 181,285 | (55,310) | | | 125,975 |
| Хувьцаан дээр үндэслсэн нөхөн төлбөр | | - | - | 1,555,634 | - | - | 1,555,634 |
| Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ | | 19,153,055 | 13,106,601 | 1,822,921 | - | - | 14,929,522 |
| 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | | 145,963,086 | $ 99,890,270 | $ 13,775,386 | $ (894,855) | $ (98,016,525) | $ 14,754,276 |

Дагалдах тайлбарууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОМПАНИ

**Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**
**(Канад доллар)**

| | Тайлбар | 12 сарын 31-нд төгссөн жил 2017 | 2016 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| Цэвэр алдагдал | | $ **(4,027,465)** | $ (2,499,739) |
| Мөнгөнөөс бусад зүйлс: | | | |
| Элэгдэл, хорогдол | | **18,285** | 14,909 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | | **1,555,634** | 535,164 |
| Санхүүгийн цэвэр орлого | | **(91,505)** | (11,955) |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал | | **37,190** | 3,341 |
| Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын борлуулалтын орлогоос хувь авах эрхээ худалдсаны олз | **7** | **-** | (623,028) |
| Түргэн борлогдох үнэт цаас борлуулсны олз | **7** | **-** | (481,064) |
| Барбадос охин компаниудыг хааснаас олсон ашиг | | **(242)** | - |
| Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт | | **(70,469)** | 9,641 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **(2,578,572)** | (3,052,731) |
| | | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| Энгийн хувьцаа, варрантын гаргалтаас орсон бэлэн мөнгөний дүнгээс гаргалтын зардлыг хассан цэвэр дүн | **12** | **13,247,913** | 1,478,858 |
| Варрант хэрэгжүүлсний орлого | **13** | **-** | 2,508,838 |
| Хувьцааны опцион хэрэгжүүлсний орлого | **13** | **125,975** | 48,150 |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **13,373,888** | 4,035,846 |
| | | | |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| Хайгуулын болон үнэлгээний ажилд зарцуулсан хөрөнгө | | **(8,613,147)** | (2,492,698) |
| Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын борлуулалтын орлогоос хувь авах эрхээ борлуулсны төлбөрт авсан түргэн борлогдох үнэт цаасыг борлуулсны орлого | **7** | **-** | 1,981,064 |
| Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн зардал | | **(77,025)** | (71,495) |
| Хүлээн авсан хүү | | **91,505** | 11,955 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **(8,598,667)** | (571,174) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд үзүүлэх валют арилжааны ханшийн зөрүүний нөлөө | | **(42,656)** | (16,522) |
| | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт | | **2,153,993** | 395,419 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд | | **1,071,209** | 675,790 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны төгсгөлд | | $ **3,225,202** | $ 1,071,209 |

Дагалдах тайлбарууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

**1. Үйл ажиллагааны чиглэл:**

Эрдэнэ Ресурс Девелопмент Компани ( “Компани ”) нь Канад улсад байрладаг Компани юм. Компаний албан ёсны бүртгэлтэй албан газар нь B3J 2V1, Халифакс, Нова Скотиа, Аппер Уотер 1300-1969 юм. 2015 он болон 2016 оны 12 сарын 31-д төгссөн Компаний жилүүдийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Компани болон түүний охин компаниуд хамрагдсан. Компаний Голлох үйл ажиллагаа нь томоохон алт болон алт-зэсийн ордуудыг бага зардлаар хайгуул хийж илрүүлэхэд төвлөрдөг. Компани нь Монгол.

**2. Үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах:**

Эдгээр санхүүгийн нэгдсэн тайлангууд нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна гэсний үндсэн дээр хийгдсэн буюу Компани урьдчилан харах боломжтой ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, өөрийн хөрөнгөө хөдөлгөж, өөрийн хариуцлага, үүрэг амлалтаа бизнесийн энгийн журмаар явуулна хэмээн таамаглаж буй. Үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нь зөв зохистой эсэхийг үнэлэхэд удирдлагын зүгээс ирээдүйн талаархи бүхий л боломжит мэдээллийг буюу хамгийн багадаа тайлант хугацаанаас арван хоёр сарыг авч үзсэн боловч үүгээр хязгаарлагдаагүй болно. Гэсэн хэдий ч үнэлгээг хийх явцдаа дараагийн догол мөрүүдэд тайлбарласан Компаний тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах ур чадварт эргэлзээ төрүүлж буй үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхгүй байдал буй талаар удирдлага ойлгож байна.

Компани хайгуулын үе шатандаа буй бөгөөд харьцуулагдахуйц ижил хайгуулын түвшинд буй компаниудын адил ижил эрсдэл, сорилтой тулгарч байна. Эдгээр эрсдлүүд нь түлхүүр хувь хүмүүсээс хамааралтай байх, амжилттай хайгуулын үр дүр, төслүүдийг амжилттай үргэлжлүүлэхэд шаардагдах хамгийн бага хэмжээний хөрөнгийг хангах зохих хэмжээний санхүүжилтыг найдвартай байлгах ур чадвар мөн тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах зэрэг юм.

Компани 2017 болон 2016 оны үйл ажиллагаанаасаа их хэмжээний алдагдалд болон сөрөг мөнгөн урсгал амсаж 2017 оны 12 сарын 31-ны байдлаар $98,016,525 алдагдалтай байна. Компани 2017 оны 12 сарын 31-нд төгссөн жилд $4,027,465 цэвэр алдагдалтай байсан бол 2016 оны 12 сарын 31-тэй харьцуулахад $2,499,739 цэвэр алдагдалтай байсан нь $1,527,726 доллараар өссөн байна. Компани 2017 оны 12 сарын 31-нд $3,229,150 эргэлтийн хөрөнгөтэй байсан бол 2016 оны 12 сарын 31-тэй харьцуулахад $965,162 байсан нь $2,263,988 доллараар өссөн байна. Удирдлагын тооцоолж буйгаар өнөөгийн эргэлтийн хөрөнгө нь Компаний төлөвлөсөн зардлыг 2018 оны хоёрдугаар хагасын төгсгөл хүртэл хангалттай санхүүжүүлэх бөгөөд хэрэв шаардлагатай гэж үзвэл төлөвлөгөөт зардлыг хойшлуулах асуудлыг сунгаж болно. Компаний үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах ур чадвар, өөрийн хөрөнгө хөдөлгөх, бизнесийн энгийн журмаар үүрэг хариуцлагаа гүйцэтгэж, өөрийн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлэх эсвэл өргөтгөх нь өмчийн санхүүжилтийн найдвартай байдал, хамтарсан үйлдвэрийн гэрээ байгуулах эсвэл хөрөнгөө мөнгөжүүлэхээс хамааралтай. Нэмэлт санхүүжилтын цаг хугацаа болон боломжит байдлыг тодорхойлоход зах зээлийн нөхцөл байдал, Компаний явуулж буй хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн ихээхэн нөлөөлнө. Компани ирээдүйд шаардлагатай санхүүжилтыг бий болгож чадна гэсэн итгэл найдвар байхгүй байна.

Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна гэсэн таамаглал зөв бус гэж үзвэл эдгээр санхүүгийн нэгдсэн тайлангууд нь шаардлагатай тохируулгуудыг тусгаагүй. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна гэсэн үндэслэл нь зөв бус бол хөрөнгийн шилжүүлгийн дүн, тайлагнасан орлого болон зардал, ашигласан санхүүгийн байр суурийн ангиллын тодорхойлолтууд шаардлагатай.

**3. Танилцуулгын үндэслэл**

a) Нийцлийн тухай мэдэгдэл

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг ОУ-ын Санхүүгийн Тайлангийн Стандартын дагуу (“ОУСТС”) бэлтгэсэн.
Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг 2018 оны 3 сарын 26-ны ТУЗ-ын хурлаар баталсан.

b) Хэмжилтийн үндэслэл
Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг түүхэн зардлын үндэслэлийн дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд багтсан Компаний охин компани тус бүрийн зүйлс нь тухайн компани бүр үйл ажиллагаагаа явуулдаг анхдагч эдийн засгийн орчны валютыг ашиглан хэмжсэн (“үйл ажиллагааны валют”). Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Канад доллараар илэрхийлсэн нь Эрдэнэ Ресурс Девелопмент Компаний ашигладаг, түүнийг төлөөлдөг валют юм. Компаний Монгол охин компаниудын ашигладаг валют нь Монгол төгрөг.

c) Тооцоолол болон үндэслэлийг ашиглах
Санхүүгийн тайлангийн бэлтгэл ажил Компаний удирдлагыг тайланд дурдсан актив, пассивын тоо хэмжээнд нөлөөлөхүйц тооцоолол болон таамаглалыг дэвшүүлж, санхүүгийн тайлангийн өдрөөрх актив, пассивын мэдээллийн тодруулга, тайлангийн үед мэдээлсэн орлого, зардлын дүн хэмжээг гаргахыг шаардсан. Тооцооллыг гаргах явцад олон төрлийн таамаглалд үндэслэсэн шийдвэрийг гаргах хэрэгтэй болсноос гадна түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт түүхэн туршлага шаардлагатай байсан. Бодит үр дүн нь эдгээр тоооцооллоос зөрөх магадлалтай. Удирдлагын тооцоолол болон таамаглалыг шаардах илүү нарийн хэсгүүдийг доор хэлэлцсэн.

Нягтлан бодох бүртгэлийн онцгой тооцооллууд:

*Санхүүгийн бус хөрөнгийн нөхөн төлөгдөх байдлын тооцоолол*

Хэрэв хөрөнгө үнэ цэнийн бууралттай байх магадлалтай гэсэн үзүүлэлтүүд байвал Компани хөрөнгийн нөхөн төлөгдөх дүн хэмжээг тооцоолох шаардлагтай. Хөрөнгийн нөхөн төлөгдөх дүн эсвэл бэлэн мөнгө бий болгох нэгжийг илүү өндөр зах зээлийн үнээр, арай бага зардал болон хэрэглээний үнээр хэмжигддэг.

*Санхүүгийн бус хөрөнгийн нөхөн төлөгдөх байдлын тооцоолол (үргэлжлэл)*

Зөвхөн одоогийн байдалд буй хөрөнгийн үргэлжилсэн хэрэглээнээс мөн түүний эцсийн хэрэглээнээс өсөхөөр хүлээгдэж буй үед Ашиглагдаж буй үнийг ихэнхдээ ирээдүйн бэлэн мөнгөний урсгалын одоогийн үнээр тодорхойлдог. Одоогийн үнийг эрсдэлд тохируулсан татварын өмнөх түвшинг хөрөнгөд буй өөрийнх нь эрсдэлтэй тохируулж тодорхойлдог.

Ирээдүйн мөнгөний урсгал нь хүлээгдэж буй үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ (одоогийн болон түүхэн үнэ, үнийн чиг хандлага, холбогдох хүчин зүйлүүдийг авч үздэг), нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээлтийн зардал ба ирээдүйн хөрөнгийн зардлаас хамааралтай.

**3. Танилцуулгын үндэслэл (үргэлжлэл)**

Нягтлан бодох бүртгэлийн онцгой тооцооллууд (үргэлжлэл)

*Хувьцаанд суурилсан төлбөр*

Өмчид суурилсан, хувьцаанд суурилсан төлбөрийг зах зээлийн үнийг олгож буй өдрөөр хэмждэг (зах зээлд суурилаагүй хөрөнгө оруулалтын нөхцлийн нөлөөг хасаад). Зах зээлийн үнийг Блайк-Шолесийн үнийн загварыг ашиглаж хэмждэг ба энэ нь хүлээгдэж буй хэлбэлзэл, зах зээлийн үнийг хэмжиж буй цаг үед бэлэн буй мэдээлэлд үндэслэсэн хүлээгдэж буй мөчлөг гэх мэт хувьсагчидтай холбоотой шийдлийг хэрэглэхийг шаарддаг.

*Талбайн нөхөн сэргээлтийн тухай заалт*

Удирдлагын зүгээс жилийн хугацаанд бий болсон баримт, нөхцөлд үндэслэн талбайн сэргээлтийн тухай шийдвэр шаардлагагүй гэж үнэлсэн.

*Хайгуул, үнэлгээний хөрөнгө*

Удирдлага төсөл эсвэл хайгуулын талбайн боломж буй тодорхой болсон эсэх дээр шийдвэр гаргахад дараагийн хайгуул, үнэлгээний зардлыг хөрөнгөжүүлнэ. Удирдлага нь техникийн судалгаа, арилжааны чадамжийг нөөцийн төслүүд бий болгож чадах эсэхийг шийднэ. Нэгэнт техникийн судалгаа болон арилжааны чадамжийг нөөцийн төслүүд бий болгож чадна гэвэл хайгуулын зардлыг төсөл, үйлдвэр, тоног төхөөрөмжид өөр нягтлан бодох бүртгэлтэй уялдуулан дахин ангилна. 2017 оны 12 сарын 31-д удирдлага ийм дахин ангилал шаардлагагүй гэж тооцсон.

**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт**

Дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь хэрэв өөрөөр дурдаагүй бол эдгээр санхүүгийн нэгтгэсэн тайланд дурдсан бүх хугацаанд нийцэж буй.

a) Нэгтгэлийн үндэслэл

2017 оны 12 сарын 31-нд төгссөн жилийн хувьд санхүүгийн нэгдсэн тайланд орсон Эрдэнэ Ресурс Девелопмент Компани болон түүний охин компаниуд: Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК мөн Лидер Эксплорйешн ХХК (Монгол хайгуулын компаниуд) юм. 2017 оны 2 сарын 6-нд Компани өөрийн Барбадос холдинг компаниуд болох Эрдэнэ Гоулд Интернейшнл Инк. болон Эрдэнэ Интернейшнл Эксплорейшн Инк-ийг хаасан гүйлгээнээс олсон $242-ийн цэвэр орлогыг Байгууллага болон Захиргааны зардлуудад бүртгэгдсэн.

2016 оны 12 сарын 31-нд төгссөн жилийн хувьд санхүүгийн нэгдсэн тайланд орсон Эрдэнэ Ресурс Девелопмент Компани болон түүний охин компаниуд: Эрдэнэ Гоулд Интернейшнл Инк болон Эрдэнэ Интернейшнл Эксплорейшн Инк (Барбадос холдинг компаниуд); мөн Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК (Монгол хайгуулын компаниуд). Эрдэнэ Гоулд Интернейшнл Инк болон Эрдэнэ Гоулд Интернейшнл Эксплорейшн Инк нь Канад долларын валютаар үйл ажиллагаагаа явуулдаг. Эрдэнэ Монгол ХХК ба Аниан Ресурс ХХК Монгол Төгрөгийн валютаар үйл ажиллагаагаа явуулдаг. Лидер Эксплорйешн ХХК-с бусад бүх охин компаниудыг бүрэн эзэмшдэг.

**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)**

Нэгтгэлийн үндэслэл (үргэлжлэл)

i) Охин компаниуд

Охин компаниуд нь Компани санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг нь захирч тэдний үйл ажиллагаанаас ашиг олдог хуулийн этгээдүүд юм. Компани өөр байгууллагад хяналт тавьдаг эсэхийг үнэлэхдээ одоо хэрэгжиж болох эсвэл хөрвөх чадвартай саналын эрх буй эсэх мөн түүний үр нөлөөг авч үздэг.

Охин компаниудын санхүүгийн тайланг толгой Компаний ижил тайлангийн хугацаанд бэлтгэдэг. Хэрэв шаардлагатай бол тохируулгыг охин компаниудын санхүүгийн тайланд хийж толгой Компаний ашиглаж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлдэг.

Охин компаниудыг Компани д хяналтыг шилжүүлсэн өдрөөс бүрэн нэгтгэсэн ба Компани ас хяналтыг авсны дараах өдрөөс нэгтгэхээ больсон. Охин компаний өмчлөлийн ашиг сонирхолд гарсан өөрлчлөлт нь хяналтын алдагдалд хүргээгүй бол үүнийг өмчийн гүйлгээ хэмээн үзнэ.

ii) Нэгтгэл дээр хассан гүйлгээнүүд

Компаний дундын үлдэгдэл, гүйлгээнүүд мөн Компани дундын гүйлгээнээс үүссэн аливаа хэрэгжээгүй орлого зарлагыг санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэх явцад хассан.

b) Гадаад валют

i) Гадаад валютын гүйлгээ

Хуулийн этгээд тус бүрийн санхүүгийн тайланг бэлтгэж байхад хуулийн этгээдийн ашигладагаас өөр валютаар (гадаад валют ) хийсэн гүйлгээг тухайн өдрийн гүйлгээнд давамгайлж буй валютын ханшаар тооцно. Тайлангийн төгсгөл бүрийн хувьд гадны валютаар үнэ буурсан мөнгөн зүйлсийг тухайн өдрийн гүйлгээнд давамгайлж буй валютын ханшаар дахин хөрвүүлнэ. Гадаад валютаар тооцсон мөнгөн бус зүйлсийг түүхэн зардлыг дахин хөрвүүлээгүй.

Төлбөр тооцоо нь төлөвлөгдөөгүй эсвэл гарах боломжтой /тиймээс гадны үйл ажиллагаанд цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг болж буй/ гадны үйл ажиллагаанаас хүлээн авах эсвэл түүнд төлөх мөнгөн зүйлсийн валютын ханшны зөрүүнээс бусад үед Мөнгөн зүйлсийн валютын ханшны зөрүүг тухайн өсч буй хугацаанд нь ашиг, алдагдлаар нь тооцно. Ингэхдээ эхэндээ үүнийг дэлгэрэнгүй орлого болон хуримтлагдсан данснаас мөнгөн зүйлсийн нөхөн төлбөрийн ашиг, алдагдал хүртэл дахин ангилсан.

ii) Гадаад үйл ажиллагаанууд

Ашигладаг валют нь танилцуулгад өөр валюттай хуулийн этгээдүүдийн үр дүн болон санхүүгийн байр суурийг дараах байдлаар танилцуулгын валют руу хөрвүүлэв:

- Актив болон пассивуудыг санхүүгийн байр суурийн тайлангийн өдрийн хаалтын ханшаар хөрвүүлэв;
- Орлогын тайлан тус бүрийн орлого, зардлыг сарын дундаж валютын ханшаар хөрвүүлэв; мөн

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

Гадаад валют (үргэлжлэл)

- Бүх гарч буй ханшийн зөрүүг өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэмээн тооцов (“хуримтлагдсан хөрвүүлгийн данс”)

Гадны үйл ажиллагааны хяналтын алдагдлын хувьд бүх ханшийн зөрүүг Компаний эзэмшигчидтэй холбоотой үйл ажиллагааны өмчөөр хуримтлуулсан ба орлогын тайланд борлуулалтын ашиг эсвэл алдагдал байдлаар бичсэн.

c) Санхүүгийн хэрэгслүүд

i) Санхүүгийн хөрөнгүүд

Компани эхэндээ зээл, авлага болон хадгаламжийг үүссэн өдрөөр нь бичдэг байсан. Бусад бүх санхүүгийн хөрөнгийг эхлээд Компани тухайн хэрэгслийн гэрээт эрх бий болсон арилжааны өдрөөр тодорхойлдог байсан.

Компани хөрөнгөнөөс мөнгөний урсгалын гэрээт эрх дуусах санхүүгийн хөрөнгийг эсвэл санхүүгийн хөрөнгөн дээр мөнгөний гэрээт урсгалыг хүлээн авах эрхийг шилжүүлэхийг үл тодорхойлдог.

*Зээл, авлага*

Зээл болон авлага нь тогтсон эсвэл идэвхтэй зах зээл дээр үнийн саналгүй тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Ийм төрлийн хөрөнгийг эхэндээ зах зээлийн үнэ дээр нэмэх нь аливаа шууд холбогдох гүйлгээний зардал гэж тооцдог байсан. Дараа нь эхэн шатны зээл болон авлагыг үр ашигтай хүүгийн арга, аливаа бага үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг.

Зээл, авлага нь авлага болон бэлэн мөнгөнөөс бүрдэнэ.

Мөнгө нь гарт буй мөнгө ба эрэлтэт ордоос бүрдэнэ.

*Зах зээлийн үнэ*

Зах зээлийн үнэ гэдэг нь зах зээлд оролцогчид хоорондоо хэмжилтийн өдөр хөрөнгийг дэс дараалалтай гүйлгээний дагуу борлуулах эсвэл хариуцлагыг шилжүүлэхээр төлбөр төлөхөөр хүлээн авсан үнэ юм. Зах зээлийн үнийн эрэмбэ нь зах зээлийн үнийг хэмжихэд ашиглах үнэлгээний техникийн орцуудыг ангилах түвшинг бий болгдог.

Түвшин 1: Орцуудыг идэвхтэй зах зээл дээр ижил төрлийн хөрөнгө эсвэл хариуцлагын хувьд үнийн саналаар илэрхийлнэ (тохиргоо хийгээгүй).

Түвшин 2: Орцуудыг идэвхтэй бус зах зээлийн үнийн саналаар илэрхийлсэн, идэвхтэй зах зээл дээр ижил төрлийн хөрөнгө эсвэл хариуцлагын хувьд үнийн саналаар илэрхийлсэн, үнийн саналаас бусад орцуудын хувьд актив, пассивыг нь ажиглах боломжтой (жишээ нь хүүгийн түвшин ба өгөөжийн муруйг нийтлэг үнийн саналын интервал дээр ажиглах боломжтой, шилжүүлэг үнийн муруйг ашиглан валют болон түүхий эдийн гэрээг үнэлэх боломжтой, хэлбэлзлийн хэмжилтийг ашиглан опционы гэрээг үнэлэх мөн боломжтой бол зээлийн эрсдлийг тохируулахын тулд зээлийн дефолт солилцоог түгээх боломжтой ажиглалт), эсвэл орцууд нь ажиглаж болох зах зээлийн дата эсвэл бусад аргаар ихэвчлэн гаргаж болох эсвэл нотолж болох.

**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)**

Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

*Зах зээлийн үнэ (үргэлжлэл)*

Түвшин 3: Орцуудыг ажиглах боломжгүй (зах зээлийн үйл ажиллагаа дэмждэггүй бага, эсвэл байхгүй).

Зах зээлийн үнийн эрэмбэ нь Түвшин 1-ийн орцод хамгийн их ач холбогдлыг өгч бу бол Түвшин 3-т хамгийн бага ач холбогдлыг өгч байна.

ii) Санхүүгийн хариуцлага

Бусад бүх санхүүгийн хариуцлагыг эхлээд Компани тухайн хэрэгслийн гэрээт эрх бий болсон арилжааны өдрөөр тодорхойлдог байсан. Ийм төрлийн санхүүгийн хариуцлагыг эхлээд зах зээлийн үнэ дээр нэмэх нь аливаа шууд холбогдох гүйлгээний зардлыг нэмж тооцдог. Эхэлж тооцсоны дараа эдгээр санхүүгийн хариуцлагыг үр ашигтай хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг.

Компани гэрээт хариуцлагаас гарсан, түүнийг цуцалсан эсвэл тэр нь дууссан бол санхүүгийн хариуцлага тооцохгүй.
Компани дараах үүсмэл бус бусад санхүүгийн хариуцлагатай: худалдаа ба бусад өглөг.

iii) Хувьцааны хөрөнгө

Энгийн хувьцааг өмч хэмээн ангилдаг. Энгийн хувьцаа, хувьцааны опцион гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг өмч, татварын цэвэр нөлөөний бууралтаар тооцдог.

d) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Хайгуулын өмнөх зардлыг гарсан зардал гэнэ. Нөөцийн төсөл худалдан авахтай холбоотой бүх шууд зардлыг төслөөр хөрөнгөжүүлнэ.
Хайгуулыг төсөл эсвэл талбайн боломжийг тодорхойлж, ТУЗ-аар батлагдаж хайгуул, үнэлгээний зардал хөрөнгөжих хүртэлх хугацаанд гарсан үйл ажиллагаагаар нь зардлыг тооцдог.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг эхлээд зардал байдлаар мөн биет хөрөнгөөр хэмждэг. Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд хайгуул хийх, судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг, суваг, дээж авах эрхийг олж авах болон төслийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бусад шууд зардлууд орно. Төслийн техник эдийн засгийн болон арилжааны үүднээс боломжтой эсэхийг тодорхойлохын тулд тодорхой ашиг сонирхолтой холбоотой ажлыг урагшлуулах шийдвэр гарсан бол холбогдох хайгуул, үнэлгээний хөрөнгийг үнэ цэнийн бууралтаар нь туршиж, балансыг нөөцийн төсөл, үйлдвэр, тоног төхөөрөмжийн хувьд дахин ангилна.

Хайгуул, үнэлгээний үнэ цэнийн бууралтыг нягтлахдаа хөрөнгийн шилжүүлгийн дүн нь нөхөн төлөгдөх дүнгээс давж байвал тус бүрээр нь эсвэл мөнгө бий болгох нэгжийн түвшинд гүйцэтгэнэ. Энэ зүйл бий болоход илүүдлийг тодорхойлсон санхүүгийн жилд нь шилжүүлгийн дүнгийн эсрэг бүрэн барина. Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тогтмол дахин үнэлдэг ба эдгээр зардлыг хамгийн багадаа дараах нөхцлүүдийн аль нэг нь хангагдсан үед шилжүүлнэ:

**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)**

d) Хайгуул ба үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

- Эдгээр зардлууд нь сонирхож буй газар амжилттай хөгжил болон хайгуулаар дамжуулан дахин буцааж авах эсвэл борлуулалтаар; эсвэл
- Сонирхож буй газар хайгуул, үнэлгээний үйл ажиллагаа нь оршиж буй талаар найдвартай үнэлгээний эсвэл бусад эдийн засгийн нөхөн төлөгдөх нөөцийн шатандаа хараахан хүрээгүй мөн идэвхтэй, чухал үйл ажиллагаа тухайн талбайд үргэлжлээгүй эсвэл ирээдүйд төлөвлөгдөөгүй.

d) Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж

*Тооцох ба хэмжилт*

Төслийн бүх эд зүйлс, үйлдвэр болон тоног төхөөрөмжийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлаар хуримтлагдсан түүхэн зардлаар хэмждэг.

Зардал нь хөрөнгийг олж авахтай шууд холбоотой зардлууд багтана. Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртөг нь материалын өртөг, шууд хөдөлмөрийн зардал болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бий болгоход шууд хамаарах бусад зардал багтаадаг.

*Дараагийн зардлууд*

Дараагийн зардал нь хөрөнгийн шилжүүлгийн дүн эсвэл аль зохимжтой үед буюу зөвхөн эд зүйлтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн ашиг Компани руу урсах мөн эд зүйлийг найдвартай хэмжиж болох үед тусдаа хөрөнгө гэж тооцогдсон.
өртгүүдийг хөрөнгийн дансны үнэд багтаан эсвэл эсвэл тусад нь эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Компани руу урсах магадлалтай бөгөөд тухайн зүйлийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд л тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Солих эд ангийн шилжүүлгийн дүнг үл тооцно. Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний өртөгийг гарах үед ашиг, алдагдлаар тооцно.

*Элэгдэл*

Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн элэгдлийг тооцоолохдоо тэдгээрийн зардал, үлдэх үнэ цэнийн цэвэр дүн, ашиглалтын тооцоолсон хугацааг хуваарилах бууралтын балансын арга эсвэл зарим тохиолдолд түрээсийн үйлдвэр, тоног төхөөрөмжийн хувьд арай бага түрээсийн хугацаатай бол дараах хэмжээгээр тооцно:

| **Хөрөнгө** | **Суурь** | **Хэмжээ** |
|---|---|---|
| Тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил | Буурч буй үлдэгдэл | 30% |
| Програм хангамж, комьпютерь | Буурч буй үлдэгдэл | 20% |
| Тээврийн хэрэгсэл | Буурч буй үлдэгдэл | 33% |

Хэрэв тохиромжтой бол элэгдлийн аргууд, ашиглалтын хугацаа, үлдэх үнэ цэнийн дүнг санхүүгийн жилийн төгсгөл тутамд хянаж тохируулна.

f) Үнэ цэнийн бууралт

Санхүүгийн бус хөрөнгө

**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)**

Компаний санхүүгийн бус хөрөнгийн шилжүүлгийн дүн нь хайгуул, үнэлгээний хөрөнгийг хасаад үнэ цэнийн бууралтын үзүүлэлт байсан эсэхийг тодорхойлохоор тайлант хугацаа бүрт хянан шалгагддаг. Хэрэв тийм үзүүлэлт буй бол хөрөнгөний төлөгдөх дүнг тооцоолно.

Хөрөнгөний төлөгдөх дүн эсвэл мөнгө бий болгох нэгж нь ашиглагдаж буй үнэ цэнээсээ илүү байдаг ба түүний зах зээлийн үнэ нь хөрөнгийг борлуулах өртөгтэй холбоотой нэмэлт зардлаас бага байдаг. Ашиглагдаж буй үнийг үнэлэхэд тооцоолсон ирээдүйн мөнгөний урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэлэмжийн өнөөгийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх бууралтын зэрэг мөн хөрөнгөд хамааралтай тусгай эрсдлийг ашиглан өнөөгийн үнэд нь бууруулдаг. Үнэ цэнийн бууралтыг туршихын тулд хөрөнгийг хамтад нь бусад хөрөнгө эсвэл хөрөнгөний бүлгийн мөнгөний урсгалаас тусдаа байх үргэлжилсэн хэрэглээнээс мөнгөний урсгал бий болгодог жижиг хөрөнгөний бүлэгт бүлэглэнэ ( “мөнгө -бий болгох-нэгж” буюу “МББН”).

Компаний байгууллагын хөрөнгө нь мөнгөний урсгалыг бий болгодоггүй. Хэрэв байгууллагын хөрөнгөний үнэ цэнийн бууралт байна гэсэн үзүүлэлт байвал байгууллагын хөрөнгө хамаардаг МББН-ийн нөхөгдөх дүнг тооцоолно.

Хэрэв нөхөгдөх дүнг тооцоолоход ашигладаг тооцоололд өөрчлөлт гарвал үнэ цэнийн бууралтын алдагдал нь буцаагдана. Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдал тооцоогдоогүй бол үнэ цэнийн бууралтын алдагдлын зөвхөн хөрөнгөний шилжүүлгийн дүн бууралтгүй тодорхойлогдох ёстой байсан шилжүүлгийн дүнгээс хэтрээгүй бол буцаагдана.

f) Орлогын татвар

Орлогын татвар нь одоогийн болон хойшлогдсон татвараас бүрдэнэ. Эдгээр татварууд бизнесийн нийлмэл байдал эсвэл өмч болон бусад дэлгэрэнгүй орлогоор тооцогдож буй үед ашиг эсвэл алдагдлаар тооцдог. Одоогийн татвар нь тухайн жилд татвар суутгах орлого эсвэл алдагдал дээр суутгахаар хүлээгдэж буй авлага эсвэл өглөг хэмээхдээ тайлангийн өдөр хүчинтэй болсон татварын хувь хэмжээ эсвэл хуулийн дагуу хүчинтэй болсон хувь хэмжээгээр мөн өмнөх жилүүдийн татварын өглөгтэй хийсэн тохиргоогоор тооцно.

Хойшлогдсон орлогын татварыг хариуцлагын аргаар буюу хөрөнгийн татварын суурь болон хариуцлагын хооронд үүсч буй түр хугацааны зөрүүгээр тооцдог ба санхүүгийн нэгдсэн тайлан дах эдгээрийн шилжүүлгийн дүнгээр тооцдог. Хойшлогдсон орлогын татварыг тайлант өдрийн хүчинтэй татварын хувь хэмжээгээр (мөн хууль) тооцдог ба холбогдох хойшлогдсон орлогын татварын хөрөнгийг тооцсон эсвэл хойшлогдсон орлогын татварын хариуцлагыг тооцсон бол хэрэглэх ёстой.

Хойшлогдсон орлогын татварын хөрөнгийг түр хугацааны зөрүүний эсрэг ирээдүйн боломжит татвар суутгах орлогыг хэрэглэж болох хэмжээнд тооцно. Хойшлогдсон татварыг дараах түр хугацааны зөрүүнд ашиглахгүй: бизнесийн нийлмэл бус болон нягтлан бодох бүртгэл эсвэл ашиг, алдагдлаас татвар суутгах асуудалд нөлөөлдөггүй гүйлгээн дэх хөрөнгө болон хариуцлагын анхан шатны тооцоолол ба охин компаниудад хөрөнгө оруулахтай холбоотой зөрүү, хамтын өмчлөлд буй хуулийн этгээдүүд нь боломжит ирээдүйд буцаагдахгүй. Мөн хойшлогдсон татварыг гүүдвиллын эхэн шатны тооцооллоос үүссэн түр хугацааны зөрүүнээс үүссэн татвар суутгалыг тооцохгүй.

Хойшлогдсон орлогын татварын хөрөнгө болон хойшлогдсон орлогын татварын хариуцлага нь ижил хуулийн этгээдийн хувьд ижил татварын албанаас татвар суутгаж буй мөн этгээд хуулийн дагуу одоогийн татварын хөрөнгөө татварын хариуцлагын эсрэг байршуулах эрхтэй бол оффсет хийж болно. Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж, шилжүүлсэн татварын алдагдал, бизнесийн комбинацаар авсан хөрөнгийн зах зээлийн тохиргооны элэгдэл, хорогдлоос үүсэх гол түр хугацааны зөрүү үүсдэг.

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

h) Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр

Ажилчдад өгсөн өмчөөр тооцоо хийсэн хувьцаанд суурилсан төлбөр болон ижил үйлчилгээ үзүүлж буй бусдыг олгосон өдрийн өмчийн хэрэгслүүдийн зах зээлийн үнээр хэмждэг. Зах зээлийн үнийг Блак-Шолесийн үнийн загварыг ашиглан хэмжинэ. Өмчөөр тооцоо хийсэн хувьцаанд суурилсан төлбөр хийсэн өдрийн зах зээлийн үнийг хөрөнгө оруулалтын хугацаанд хийсэн үйлчилгээ гэж тооцно. Ингэхдээ Компаний хөрөнгө оруулалт хийх цаашдын хувьцааны тооцоо болон зах зээлийн бус хөрөнгө оруулалтын нөхцлүүдэд тохируулсан тооцоон дээр үндэслэнэ. Хөрөнгө оруулалтын бус нөхцөлтэй хувьцаанд суурилсан төлбөр гардуулалтын хувьд хувьцаанд суурилсан төлбөрийг олгох өдрийн зах зээлийн үнийг хэмжиж эдгээр нөхцлүүдийг тусгах ба хүлээгдсэн болон бодит үр дүнгийн хооронд тооцоолсон дүнгийн зөрүү байхгүй.

Ажилтнуудаас бусадтай хийсэн өмчөөр тооцоо хийсэн хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээ болон ижил төрлийн үйлчилгээ үзүүлж буйг зах зээлийн үнийг найдвартай тооцоолж чадахгүй үеэс бусад тохиолдолд хүлээн авсан бүтээгдэхүүн болон үйлчилгээний зах зээлийн үнээр хэмждэг ба энэ тохиолдолд тэдгээрийг олгогдсон өмчийн хэрэгслүүдийн зах зээлийн үнээр нь мөн бүтээгдэхүүн авч буй этгээд болон үйлчилгээ авч буй талын өдрөөр хэмждэг.

i) Хувьцаа бүрийн алдагдал

Компани өөрийн энгийн хувьцаандаа суурь болон шингэрүүлсэн алдагдлыг хувьцаа бүрийн өгөгдөлд гаргадаг. Нэгж хувьцааны суурь алдагдлыг Компаний энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг тухайн хугацаанд зах зээл дээр буй нийт энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хувааж тооцно. Нэгж хувьцааны шингэрүүлсэн алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг бүх шингэрүүлэх боломжтой энгийн хувьцааны нөлөөлөлд буй зах зээл дээрх буй нийт энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд тохируулж тооцно. Бүх хувьцааны сонголтууд нь хувьцаа бүрийн алдагдлын хувьд одоогоор шингэрэлтийн эсрэг буй. Үр дүнд нь нэгж хувьцааны суурь болон шингэрүүлсэн алдагдал ижил.

## 5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарах ирээдүйн өөрчлөлтүүд

ОУСТС-ын хүрээнд хийсэн дараах шинэ стандарт, стандартад хийсэн өөрчлөлт болон тайлбарууд нь 2016 оны 12 сарын 31-нд төгссөн жилд хараахан хүчинтэй болоогүй байсан ба эдгээр нэгдсэн тайланг бэлтгэхэд ашиглагдаагүй:

<u>ОУСТС 9-д хийсэн өөрчлөлтүүд – Санхүүгийн Хэрэгслүүд</u>

